



## ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү бодлогын зорилго нь компаний хэмжээнд баримтлах цалин хөлс, урамшууллын зарчмыг тодорхойлж, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын баг болон байгууллагын нийт ажилтнуудын цалин, урамшууллын зарчим, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлно.

### ХОЁР. ЗАРЧИМ

2.1. Цалин, урамшууллын талаар байгууллагын хэмжээнд баримтлах бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

2.1.1. Ажилтны үндсэн болон нэмэгдэл цалинг ажил, үйлчилгээний онцлог, тогтвортой ажилласан жил, мэргэжил, мэргэшил, ББСБ-ын хөдөлмөрийн зах зээл дэх цалингийн жишигтэй уялдуулан тухайн жилийн төгрөгийн албан ёсны ханшийн өөрчлөлтийг тооцон цалингийн хэмжээг жил бүр өөрчлөн тогтоож болно.

2.1.2. цалин, урамшууллыг ур чадвар болон ажлын үнэлгээ, үр дүнд суурилж тогтоох;

2.1.3. хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн өсөлтийн зохистой харьцаа болон инфляцын түвшинтэй уялдуулж бодит цалинг тогтоох;

2.2. ТУЗ-ийн дэргэдэх Цалин, Урамшууллын Хороо /цаашид "Хороо" гэх/ нь БИД ББСБ-ын эрх бүхий албан тушаалтан болон ажилтнуудад олгох цалин, урамшууллыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах, холбогдох хууль тогтоомж болон ТУЗ-өөс тодорхойлсон бусад асуудлын хүрээнд дараах хэлбэрээр, зохистой хэмжээг тогтоон олгоно. Үүнд:

2.2.1. тогтмол цалин;

2.2.2. байгууллагын жилийн үр дүнг үндэслэн нэг удаа олгох урамшуулалт цалин;

2.2.3. мэргэжлийн, өндөр ур чадвартай гүйцэтгэх удирдлагыг тогтвор суурьшилтай ажиллуулах, идэвхжүүлэхэд хангалттай хэмжээний цалин, урамшуулал;

2.2.4. байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон бусад нөхцөл байдлаас шалтгаалсан бусад хэлбэрийн урамшуулал.

2.3. Хороо нь эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг ТУЗ-өөр батлуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих, холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргана.

2.4. Хороо нь байгууллагын ажилтны цалин, урамшуулалтай холбоотой дотоод дүрэм, журам, системийн үр дүнг үнэлж, холбогдох хууль тогтоомжид нийцэж буй байдалд хяналт тавих, байгууллагын цалингийн бодлого, түвшин, бүтэц, цалин тогтоох журамд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ-д тайлагнаж, ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлнэ.

ГУРАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

- 3.1 ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн гишүүдийн цалинг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн, шийдвэрлэж тогтооно.
- 3.2 ТУЗ-ийн гишүүн нь цалинтай байна. Энэхүү цалин нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд ур чадвараа дайчлан ажиллах, гишүүдийн үйл ажиллагааг идэвхижүүлэхэд чиглэсэн байна.
- 3.3 ТУЗ-ийн гишүүнд цалингаас гадна дараах хэлбэрийн нэмэгдэл цалин хөлс, урамшууллыг ТУЗ-ийн хурлын шийдвэрээр олгож болно. Үүнд:
- 3.3.1 ТУЗ-ийн удирдах цалин;
  - 3.3.2 Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үндэслэн нэг удаа олгох урамшуулал цалин;
  - 3.3.3 Бусад урамшуулал цалин;
- 3.4 ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалинг ТУЗ тогтооно.

#### ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

- 4.1 Байгууллагын нийт ажилтнуудын цалин, урамшууллыг ТУЗ тогтооно.
- 4.2 Байгууллагын үндсэн ажилтнуудын цалин хөлсний бүрдэл нь үндсэн болон нэмэгдэл цалингаас бүрдсэн байна.
- 4.3 Тухайн жилийн батлагдсан бизнес төлөвлөгөөний хүрээнд энэхүү бодлого, зарчимд нийцүүлэн байгууллагын ажилтнуудад цалин урамшууллыг олгоно.

#### ТАВ. ХЯНАЛТ

- 5.1 Энэхүү бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлд ТУЗ-ийн дэргэдэх Цалин, Урамшууллын Хороо хяналт тавин ажиллана.

-000-